

“Ололт Амжилтын Түлхүүр” ТББ-ын үйл ажиллагааны дэлгэрэнгүй танилцуулга

1. Байгууллагын танилцуулга

“Ололт амжилтын түлхүүр” ТББ нь Монгол Улсын хөгжил, бүтээн байгуулалтын төлөө баялаг бүтээн ажиллаж буй төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн ХАБЭА-н сургалт, Зөвлөх үйлчилгээг ХАБЭА-н ёс журам, хууль зүйд нийцүүлэн мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэхээр 2016 онд багуулагдсан.

Бид өөрсдийн ур чадвараа хөгжүүлэх хүсэл эрмэлзэлтэйгээс гадна, бусдыг сургах, сонсох, хөгжүүлэхэд идэвхитэй ажиллахын зэрэгцээ монгол хүний үнэлэмжийг дээшлүүлж, салбартаа өөрийн байр сууриа бэхжүүлэхийн төлөө, хамгийн шилдэг сургалт, зөвлөх үйлчилгээг үзүүлдэг байгууллага болохоор эрмэлзэн ажиллаж байна.

Манай байгууллага удирдах зөвлөл /УЗ/ ба гүйцэтгэх захирлын удирдлагатай захиргаа, хүний нөөцийн алба, сургалт судалгааны алба, зөвлөх ба гэрээт ажил үйлчилгээний гэсэн үндсэн 4 албаас бүрдэн ажиллаж байна.

❖ ХАБЭА-н сургалтууд:

- ✓ Аж ахуйн нэгж байгууллагын ажил олгогч эздийн сургалт
- ✓ Дунд шатны удирдлага, менежерүүдийн сургалт
- ✓ ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны мэргэшүүлэх сургалт
- ✓ Нийт ажилчдын сургалт
- ✓ Ажилд шинээр орж байгаа иргэн, ажилтны сургалт
- ✓ Өөр ажлын байранд шилжсэн ажилтны сургалт
- ✓ Даралтат сав, шугам хоолойтой харьцаж ажилладаг ажилтны сургалт
- ✓ Өргөх, зөөх механизмтай харьцаж ажилладаг ажилтны сургалт

❖ Зөвлөх үйлчилгээ:

- ✓ Байгууллагын үйл ажиллагаанд OHSAS 18001 стандартыг нэвтрүүлэх.
- ✓ Хуульд заагдсан ХАБЭА-н бичиг баримтын бүрдэл, сан үүсгэхэд зөвлөх.
- ✓ Ажлын байрны эрсдлийн үнэлгээ хийх.
- ✓ Байгууллагын ХАБЭА-н соёлын түвшинг тодорхойлох.

❖ Outsourcing service: / Гэрээт ажил үйлчилгээ/

Байгууллагын захиалгат гэрээт ажил үйлчилгээ.

2. Сургалтын үйл ажиллагаа

Уул уурхайн “Өсөх зоос” ХХК-тай 14 цагийн Нийт ажилчдын сургалтыг зохион байгуулах гэрээ байгуулан хамтран ажиллаж байсан.



- “Оч наран” ХХК-ы ажилчдад Оюу Толгойн төслийн хүрээнд очиж ажил гүйцэтгэхэд зориулан ХАБЭА-н сургалт явуулсан. (Үүнд: Галын аюулгүй ажиллагаа, Эмнэлгийн анхан шатны тусламж, Хөдөлмөрийн нөхцөл, эрүүл ахуй гэсэн хичээлүүд болно.)



(“Оч наран” ХХК-ы ажилчдад зохион байгуулсан нийт ажилчдын сургалт)

- ОБЕГ-ын харьяа Нөөцийн салбарийн ажилтнуудад ХБАЭА-н нийт ажилчдын сургалт явуулсан.



(ОБЕГ-ын харъяа Нөөцийн салбарт нийт ажилчдын сургалт явагдаж байна.)

- “Вагнер Ази” ХХК-ы ажилчдад “Даралтат сав, шугам хоолойтой харьцаж ажилладаг ажилтны сургалт”-ыг явуулсан.





(“Вагнер Ази” ХХК-ы даралтат савтай харьцаж ажилладаг ажилтнуудад зориулан сургалт явагдаж байна.)

- “Таван Богд Менежмент” ХХК-тай байгуулсан ХАБЭА-н сургалтын гэрээний дагуу ХАБЭА-н нийт ажилчдын сургалтыг зохион байгуулсан. Мөн Аж ахуй нэгжийн удирдлагын 8 цагийн сургалтыг зохион байгуулсан.



(Таван Богд менежмент”ХХК-ы ажилчдад ХАБЭА-н нийт ажилчдын сургалт явуулсан)



(Таван Богд менежментийн удирдлагын сургалт)

❖ Зөвлөх үйлчилгээ:

Уул уурхайн “Жавхлант орд” ХХК-тай ХАБЭА-н зөвлөх үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээн хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан.



(“Жавхлант-Орд” ХХК – уурхайн төслийн талбай дээр ажиллаж байна)

- ❖ “Амжилт Авардс-2016 “ буюу Amjilt.com–оос олон нийтийн санал асуулгаар Монгол Улсын бизнесийн салбар дахь ТОП 50 байгууллагыг шалгаруулсан арга хэмжээ болж өнгөрлөө.

Манай хамт олон тус шалгаруулалтын “ 2016 оны шилдэг сургалтын байгууллага” номинацид шалгарч илүү ихийг хийж бүтээх үүрэг хариуцлага, өндөр нэр хүндтэй өргөмжлөлийн эзэн боллоо.

Мөн “Монгол Чанар-2017” буюу Үндэсний бизнес хөгжлийн нэгдэл-ээс Байгууллагын үйлдвэр, үйлчилгээний чанар стандартад тогтмол анхаарч, МУ-ынхаа хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж буйг үнэлэн Монгол Чанар цом өргөмжлөлийг гардуулсан юм.



3. 2017 онд явуулсан үйл ажиллагааны тайлан

- ❖ Сургалт:
 - “Премиум Конкрит” ХХК-ы ажилчдад Оюу Толгой руу ажиллахад шаардагдах 3 цагийн сургалт явуулсан.(Үүнд: Галын аюулгүй ажиллагаа, Эмнэлгийн анхан шатны тусламж, Хөдөлмөрийн нөхцөл, эрүүл ахуй гэсэн хичээлүүд болно.)
 - “Оч наран” ХХК- тай ХАБЭА-н сургалт явуулах хамтран ажиллах гэрээ байгуулснаар нийт 340 ажилтанд нийт ажилчдын сургалт зохион байгуулсан.
 - “Анандын зам” ХХК-ы 49 ажилтанд нийт ажилчдын сургалт явуулсан.
 - “Арж Роуд” ХХК-ы 67 ажилчинд нийт ажилчдын сургалт явуулсан.
 - “Даралтат савтай харьцаж ажилладаг ажилтны сургалтыг “Вагнер Ази” ХХК, “Ай Ви Ко” ХХК, “Таван Богд -Вашёку” , “Талх чихэр”ХК зэрэг байгууллагын нийт 63 ажилтанд тус тус явуулсан байна.



(“Талх чихэр” ХК-дээр явагдсан даралтат савтай харьцаж ажилладаг ажилтны сургалтын явцаас)

- “УБ Гурил” ХХК –ы Дархан болон УБ салбар дээр ажлын байрны үзлэг шалгалт хийн , нийт ажилчдын сургалтыг явуулсан .



- Кран, өргөх зөөх механизмын сургалтыг “Талх чихэр” ХК, “УБ Гурил” ХХК-уудтай тус тус хамтран нийт 47 ажилтанд сургалт явуулан гэрчилгээ олгосон.




(“УБ-Гурил” ХХК дээр явуулсан сэрээт ачигчийн сургалтын онолын хичээл ба дадлагын шалгалт)

- ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны мэргэшүүлсэн сургалтыг 2017.01 сараас эхлүүлэн анхны ээлжийн оюутнуудаа хүлээн авч сургалт явуулсан бөгөөд нийт 6 ээлжийн сургалтаар 40 ажилтныг бэлтгэн төгсгөсөн байна.



(Хичээлийн явц)



(Оюутнууд өөрсдийн бэлдсэн сэдвийн дагуу илтгэл тавьж байгаа нь)



(Шалгалт өгөн гэрчилгээ гардаж байгаа нь)

“ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны мэргэшүүлсэн сургалт”-ын дадлагыг “Вагнер Ази” групп компани болон “Премиум конкрит” ХХК-тай хамтран тус байгууллагуудын ажлын байран дээр явуулж ирсэн.



(“Вагнер Ази” компани дээр хийгдсэн дадлага хичээл)

❖ Зөвлөх үйлчилгээ:

- 2017 он гарснаар манай байгууллага “Премиум конкрит” ХХК, “Ай Ви Ко” ХХК, “Жи И Ти Ди” ХХК, “Таван Богд Фүүдс” ХХК, “Хан Аттрибут” ХХК, “Магес Консалтант” ХХК зэрэг байгууллагуудтай зөвлөх үйлчилгээ үзүүлэх, хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.
- “Премиум конкрит”.
“Ололт амжилтын түлхүүр” ТББ нь ХАБЭА-н Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хамтран ажиллах гэрээ байгуулан тус байгууллагын ХАБЭА-н асуудлыг хариуцан өөрийн хүмүүсийг байршуулан ажиллаж байна.




(Өглөө бүр ажилд гарахын өмнө өдөр тутмын зааварчилга өгч хяналт тавин ажиллаж байна.)

- ❖ “АйВиКо” ХХК –тай Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан хамтран ажиллаж байгаа нь.



(Ажлын байрны үзлэг шалгалт)




(Агуулахад тэмдэг тэмдэглэгээг хийж байна)

❖ **ISO 9001:2015 Олон улсын чанарын менежмент**

Бид үйл ажиллагааныхаа чанарыг дээшлүүлж, харилцагчдийн сэтгэл ханамжийг ямагт дээшлүүлэхийг төлөө байгууллага дээрээ ISO 9001:2015 Олон улсын чанарын менежментийг нэвтрүүлэн ажиллаж байна.

- 2017.01.13-ний өдөр “ SFCS консалтинг ” ХХК –тай байгуулсан гэрээний дагуу 6 ажилтнаа сургалтанд хамруулан дотоод аудиторoor бэлтгэлээ .
- 2017.09.18 –нд “ SFCS ” ХХК баталгаажуулалтын компанитай гэрээ байгуулан ISO 9001:2015 Олон улсын чанарын менежментийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, баталгаажуулалтын 2-р шатны аудитыг хийлгэснээр ISO 9001:2015 гэрчилгээг гардан авахад бэлэн боллоо.



(ISO 9001:2015 –ын сургалтанд хамрагдаж байгаа болон өөрийн байгууллага дээр хэрэгжүүлэн баталгаажуулалт хийлгэв.)

❖ **Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн үйл ажлууд:**

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 2017.06.19-нд зохион байгуулагдсан “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т оролцсон нь .



- Азтан шалгаруулж, иж бүрэн хувийн хамгаалах хэрэгсэл, хувцас бэлэглэсэн.



- **"ОЛОЛТ АМЖИЛТЫН ТҮЛХҮҮР"** ТББ нь нийгмийн хариуцлагаа ухамсарлан утааны эсрэг тэмцэлд дуу хоолойгоо өргөх зорилгоор нийгмийн нэгж болсон гэр бүл, балчир үрсийнхээ төлөө **"УТААНЫ ЭСРЭГ ХАМТДАА"** жагсаалд нэгдэв.



- “Таван Богд” групптэй хамтран 13-р зуунд дугуйтайгаа сэдэвт дугуйн аяллыг зохион байгууллаа.

Амралтын өдөр явагдсан уг аялалд тус байгууллагын 50 орчим ажилтан хамрагдсан бөгөөд нэг өдрийг цэвэрт агаарт өнгөрүүлж, багахан боловч оюуны алжаалаа тайлсан чухал ач холбогдолтой арга хэмжээ болж өнгөрлөө.



- Монгол улсын ирээдүй болсон хүүхэд багачуудын гоо зүйн хүмүүжилд дэмжлэг үзүүлэх зорилготой “Монгол-Оркестр” ХХК-ы 49-р гудамж хүүхэд, залуучуудын албанаас санаачилсан “Хичээнгүй тусч Цогт хүү” төслийг хэрэгжүүлсэн.

Манай байгууллага уг төсөлд хамт байгаагаа илэрхийлэн 150000 төгрөгийн дэмжлэг үзүүлэн хамтран ажиллалаа.

“Ололт Амжилтын Түлхүүр” ТББ-ын сургалтын танхим

АНГИ-01 ИТА-ны АНГИ



АНГИ-02 ХАБЭА-ны АЖИЛТАН АНГИ



АНГИ-02 ХАБЭА-ны НИЙТ АЖИЛЧДЫН СУРГАЛТЫН АНГИ

